

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 11 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6
Нэг. Зохион байгуулалтын үйл ажиллагааны талаар.					
1.	“Ёс зүйн дэд хороо”-ны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал авч нэгтгэн, Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	“Ёс зүйн дэд хороо”-ны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 16 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Төлөвлөгөөний хэрэгжилт 90.6 хувьтай хэрэгжив.	100
2.	“Ёс зүйн дэд хороо”-ны төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэж, Газрын даргад танилцуулах.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100 хувь	“Ёс зүйн дэд хороо”-ны төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэж, Газрын даргад танилцуулсан.	100
3.	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээ, тайланг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Ёс зүйн дэд хорооны тайлан, мэдээг хагас жилийн байдлаар нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр бэлтгэсэн.	100
4.	Ёс зүйн дэд хорооны хурлын тэмдэглэлийг тухай бүр цаасан суурьтай албажуулах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороо 3 удаа хуралдаж, хуралдааны тэмдэглэлийг цаасан суурьтай албажуулсан.	100
5.	“Ёс зүйн дэд хороо”-ны 2024 оны үйл ажиллагааны талаарх холбогдох материалын бүрдлийг ханган Газрын Архивд хүлээлгэн өгнө.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	“Ёс зүйн дэд хороо”-ны 2024 оны үйл ажиллагааны холбогдох баримт материалыг Архивын хадгаламжийн нэгжийн дагуу архивлаж, Газрын Архивд хүлээлгэн өгсөн.	100
Хоёр. Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариу арга хэмжээ авч ажиллах талаар.					
6.	Ажилтан, албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг цаасан	Арга хэмжээний	100 хувь	“Ёс зүйн дэд хороо” болон Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажлын хэсгийн	100

	болон цахим хэлбэр (QR код)-ээр хүлээн авч бүртгэх.	хэрэгжилтийн хувь		төлөвлөгөөний дагуу гомдол, мэдээллийг хүлээж авах QR код бүхий зурагт холбоос, саналын “Хайрцаг”-ийг Газрын мэдээллийн самбар болон дотоод сүлжээнд байршуулан, ажилтан, албан хаагчдад мэдээлэл хүргэсэн. Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороонд 1 гомдол, санал ирж, бүртгэсэн.
7.	Ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийн үндэслэлийг шалган тогтоож, хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд дүгнэлт гаргаж, дүгнэлтийг холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлэх.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Ёс зүйн зөрчил гаргасан тухай 1 гомдол мэдээллийг Ёс зүйн дэд хорооны 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хуралаар хэлэлцүүлэн, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан хаагч болон удирдлагад танилцуулсан.
8.	Ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хадгалах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, ажлын сахилга хариуцлага алдаж холбогдох хууль, журмын дагуу албан тушаалтанд хариуцлага тооцох нөхцөл байдал үүсээгүй тул ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэр гараагүй байна.
9.	Ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагчийг танхимын давтан сургалтад хувийн зардлаар хамруулна.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар ёс зүйн зөрчил гаргаж, хариуцлага хүлээлгэсэн албан хаагч байхгүй.
Гурав. Сургалт, соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар.				
10.	Газрын ажилтан, албан хаагчдын “Ёс зүй, харилцаа хандлага”-ын талаар судалгаа авч, дүнг нэгтгэн Газрын даргад танилцуулах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ёс зүйн тухай ойлголт, мэдлэг болон үйл ажиллагаандаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөж буйг тодруулж судалгааны үр дүнд үндэслэн үйл ажиллагаа төлөвлөж ажиллах зорилготой “Ажилтан, албан хаагчдын харилцаа, хандлагын талаарх судалгаа”-г албан 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд цахимаар авч, судалгааны үр дүнд үндэслэн зөвлөмж боловсруулан, газрын дарга болон нийт алба хаагч нарт танилцуулсан.

11.	Шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад Газрын “Ёс зүйн дүрэм”-ийг танилцуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар шинээр томилогдсон нийт 16 албан хаагчид Ёс зүйн дүрмийг танилцуулсан ба 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр манай газарт 2024, 2025 онд шинээр ажилд томилогдсон ажилтан, албан хаагч нарт Газрын ёс зүйн дүрэм болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэдлэг, мэдээлэл өгөх зорилготой “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад 29 албан хаагч хамрагдсан.	100
13.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын талаар танилцуулга, мэдээлэл бэлтгэж Газрын дотоод сүлжээ, мэдээллийн самбарт 10-аас доошгүй удаа байршуулж, сурталчлах, мэдээлэх.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Албан хаагчдын ёс зүй, ёс суртахууны тухай мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилготой “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Газрын ёс зүйн дүрэм”, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)”, Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/62 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03/2617 дугаарын албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны харьяа байгууллагын нийт албан хаагч нарт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Ажлын байранд дээрх ёс зүйн хэм, хэмжээг мөрдөж ажиллахыг анхааруулсан тухай мэдэгдэл болон Академич, доктор профессор, хуульч С.Нарангэрэлийн “Ёс суртахуун, ёс зүй гэж юу вэ” сэдэвт мэдээлэл болон аян үйл ажиллагааны хүрээнд уриалга мэдээллийг тус тус постер байдлаар бэлтгэн нийт 11 удаа дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад мэдээлэл хүргэсэн. Мөн Газрын мэдээллийн самбарт тухай бүр нь мэдээллийг байршуулж мэдээлэл хүргэсэн байна.	100

14.	Газрын нийт албан хаагчдад “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт”-ыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах (Холбогдох хууль, тогтоомжийн талаар товч мэдээлэл танилцуулга болон Төрийн байгууллагад гарч буй аелига, хүнд суртал, ёс зүйн зөрчлийн бодит кейс, шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл, Төрийн албаны үнэт зүйлс, ёс зүй, харилцаа хандлага, Ажлын байрны хортой уур амьсгал г.м)	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Мөн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран нийт 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 255 албан хаагчийг хамруулав. Үүнд: 1. 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулж, сургалтыг Хууль зүйн доктор, судлаач багш Л.Мөнх-Эрдэнэ удирдан явуулж, ёс зүй, ёс суртахууны тухай ойлголт болон холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчдын нийтлэг гаргаж буй алдаа, түүнээс урьдчилан сэргийлэх практик, жишээг дурдан мэдлэг мэдээлэл өгч, сургалтад нийт 48 ажилтан, албан хаагч, 2. 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр "Ашиг сонирхол ба нөлөөлөх хүчин зүйл"-ийн тухай сургалтад 50 албан хаагч, 3. 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр манай газарт 2024, 2025 онд шинээр ажилд томилогдсон ажилтан, албан хаагч нарт Газрын ёс зүйн дүрэм болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэдлэг, мэдээлэл өгөх зорилготой “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад 29 албан хаагч, 4. 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Хууль зүйн ухааны доктор, судлаач багш Л.Мөнх-Эрдэнэ удирдан явуулж, Ажлын байрны бэлгийн дарамтын тухай ойлголт болон нийгэмд гарч байгаа нийтлэг алдаа, түүнээс урьдчилан сэргийлэх практик, жишээг дурдан холбогдох хууль,	100
-----	--	---	-----------------	---	------------

				хаагчдад хүргэж, албан хаагчдын оролцоог дэмжиж ажилласан. Мөн ажлын цаг ашиглалтыг сайжруулах чиглэлээр хамт олныг уриалж, ажлын цагаа баримтлан ажлын цаг хоцролтгүй нийт 3 хэлтсийн шалгаруулан, урамшуулж, мэдээллийг Газрын дотоод сүлжээнд TEAMS программын “НХОГ” группд байршуулан хамт олныг уриалж ажилласан.	
16.	Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх чиглэлийн сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүдийг хамруулна.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Тайлант хугацаанд ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх чиглэлийн сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүдээс хамрагдаагүй болно.	0
Дундаж хувь					93.7

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.МӨНХБАТ

Ц.ГҮРБАДАМ

Г.ИЖИЛМАА